

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН  
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛСАН  
ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 04 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 8 гишүүнээс 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчдын зүгээс уг хуулийн төсөл батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үр ашигтай үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх, олон улсын менежментийн багаар удирдуулах, нээлттэй хувьцаат компани болгох, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлэхэд чухал алхам болно гэж үзжээ. Мөн хуулийн этгээдийн хэлбэрийг Иргэний хуультай нийцүүлснээр хуулийн этгээдийн засаглал ойлгомжтой болж, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын үзэмжээр аж ахуй эрхлэх нөхцөлийг хязгаарлах, төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох сөрөг үр дагаврыг бууруулна гэж үзсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат төрийн өмчит компанийн ажилчдад хувьцааных нь тодорхой хувийг олгодог гадны туршлагыг судалж, энэ хуулийн төсөлд тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Мөнхсоёл нар тус хуулийн төслийг Нийтийн өмчийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай анхдагч хуулийн төслүүдтэй давхардуулж хэлэлцэх шаардлагатай эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан төрийн өмчит үйлдвэрийн газар гэсэн статуст ямар компаниуд багтаж байгаа талаар болон “Эрдэнэт үйлдвэр”-ийн хувь эзэмшлийн асуудал дээр өөрчлөн байгуулах процессыг ямар арга хэлбэрээр хэрэгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай компанийн хэлбэр өөрчлөгдөхөд аль хуулиар зохицуулах, үүнд шаардагдах зардлын тооцооллын талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар гишүүд хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар байр сууриа илэрхийлэх үед Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал төрийн өмчит үйлдвэрийн газар гэсэн статуст төрийн өмчийн их, дээд сургуулиуд болон уул уурхайн компаниуд хамт багтаж байгаа ойлгомжгүй асуудлыг яаралтай шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа энэ хуулийн төслийг Нийтийн өмчийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай анхдагч хуулийн төслүүдтэй нэгтгэн хэлэлцэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн хамт өргөн мэдүүлсэн Хууль

хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл Байнгын хорооны анхны хэлэлцүүлгийн шатанд байгаа БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төсөлтэй давхцаж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Нийтийн өмчийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай анхдагч хуулийн томоохон төслүүдийг Улсын Их Хурал батлах, хэрэгжүүлэхэд тодорхой цаг хугацаа шаардлагатай тул эдгээр хуулиуд батлагдах хүртэл хугацаанд энэ хуулийн төслийг яаралтай хэлэлцэж батлан, үүсээд байгаа асуудлуудыг шийдвэрлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай төрийн өмчийн компаниудын засаглалыг сайжруулах, нээлттэй хувьцаа эзэмшилтэй болгох механизмыг хуулинд нарийвчилж тусгах шаардлагатай талаар тус тус саналаа хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ**



**С.ЦЭНГҮҮН**